



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 589

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 159,000,000.00 /нэг зуун тавин есөн сая/ төгрөгийн балансын үнэ, 23,849,999.91 /хорин гурван сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Мэндсайхан, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001156

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
589 дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Засгийн
газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт
балансаас балансад шилжүүлэх автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузер- 200, 04-41 УБУ, арал № JTMNU01J7J41 60658	2017/ 2018	159,000,000.00	23,849,999.91	135,150,000.09
	Нийт дүн		159,000,000.00 /нэг зуун тавин есөн сая/	23,849,999.91 /хорин гурван сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө/	135,150,000.09 /нэг зуун гучин таван сая нэг зуун тавин мянган төгрөг есөн мөнгө/